



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 1/307

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлж буй Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь төслийн орон нутаг дахь зохицуулагч нарын хөдөлмөрийн хөлс, үйл ажиллагаанд зарцуулагдах зардлын 41,185,868 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.


2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 41,185,868 төгрөг (дөчин нэгэн сая нэг зуун наян таван мянга найман зуун жаран найман)-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолын 6 дугаар хавсралт дахь "Байгаль орчинг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааны санхүүжилтээр хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний жагсаалт"-ын 3.2 дахь заалт аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байгаль орчны зорилтуудыг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01ah 1546



**“БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ,
УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ НЬ” ТӨСЛИЙН
АЖИЛЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН ХӨЛС, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ**

Д/д	Овог, нэр	Албан тушаал	Сарын цалин	Ажиллах сар	Жилийн хөдөлмөрийн хөлс, үйл ажиллагааны зардал	НДШ /ажил олгогчоос 12.5%/	Жилийн хөдөлмөрийн хөлсний нийт зардлын дүн /төгрөг/
1.	Ч.Мөнгөнхүү	Хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтан	1.016.935	12	12 203 220	1 524 403	13 727 623
2.	Э.Удвал	Мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан	1.016.935	12	12 203 220	1 524 403	13 727 623
3.	Д.Одончимэг	Төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн	1.016.935	12	12 203 220	1 524 403	13 727 623
НИЙТ ДҮН					36 609 660	4 576 208	41 185 868

-оОо-